

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ 2023 ОНД  
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ**

**Нэг. Адаацаг сумын ЗДТГ (Хууль эрх зүйн хэлтэс)**

- Иргэд олон нийтэд зохион байгуулах сургалтыг улиралд 4 удаа зохион байгуулах.
- Авлигаас урьдчилан сэргийлэх аян, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж хэвшүүлэх.
- “Шударга ёс хөгжил дэвшилд-110” мэдээллийн самбар ажиллуулах.
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажил, арга хэмжээг зохион байгуулах.
- Баримтын бүртгэлийг байгууллагын БНШК-ын хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулах.

**Санхүү, төрийн сангийн хэлтэс**

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь сар бүр жигд биелүүлэх

**ТЗУХ**

Тайланг хуваарийн дагуу хугацаандаа ирүүлэх

Хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг бичихдээ тухайн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хувь, тоотой харьцуулж үзэх хувь, тоог баримтыг бичих

Зарим сумд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд тусгагдсан заалтуудыг хэрэгжилтийг ирүүлээгүй орхисон

Хэрэгжилтийн үр дүн бичдэггүй, дутуу тайлагнадаг, үг үсгийн алдаатай, найруулга зүй байхгүй, баримт бичгийн стандартыг мөрдөөгүй.

Хэрэгжилт дээрээ тоо бичиж ирүүлдэг.

**НБХ**

1. Хугацаа болоогүй гэсэн заалтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацааг тайланд бичих.
2. Аймгийн “Шатар” хөтөлбөрийг болон “ЗХЗ” сагсан бөмбөгийн спортыг орон нутагт хөгжүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын 2023 оны 01/681 тоот албан бичгээр хүргүүлсэн төлөвлөгөөнүүдэд тусгагдсан холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах
3. Уртын дуу, морин хуурын сургалтыг яаралтай зохион байгуулж, 3000 морин хуурч, уртын дуучдын эвент наадамд тус гэрээний хавсралтын дагуу квотоор оролцох
4. Ковид-19 халдварын эсрэг дархлаажуулалтад зорилтот бүлгийн иргэдийг хамруулах
5. Хүн амын халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлтэд Иргэдийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх
6. 18-аас дээш насны хүн амыг зүрх судасны өвчний эрсдэлийн түвшин тогтоох үзлэгт хамруулах хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх
7. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр 2023 онд аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах
8. Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрх бий болгох ажлыг шалгаруулах арга хэмжээг зохион байгуулах
9. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх, тандалтын үйл ажиллагааг эрчимжүүлэн эм эмнэлгийн хэрэгсэл, хүний нөөцийн бэлэн байдлыг хангаж ажиллах
- 10.4.2 Эрүүл мэндийн үзлэгт эрэгтэйчүүдийг хамруулах төлөвлөхдөө тодорхой тусгах, уг төлөвлөлтөд зөвхөн төрийн албан хаагч биш нийт эрэгтэйчүүдийн хамрах хувийг тусгасан байна. Иймд сумын хэмжээнд хэдэн эрэгтэй үзлэгт хамрагдахаас хэдэн хүн хамрагдсан талаар тайлагнана.

11. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны ажилд зуучилсан иргэний мэдээллээ Хөдөлмөр эрхлэлтийн e-job программд оруулж ажиллах /Нотлох баримтыг программаас гаргаж ирүүлэх/
12. Тайлагнахдаа төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд хүрсэн эсэхийг тодорхой бичих. Жишээлбэл: 4.6 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний орчин, орон зайн стандартын үзлэг зохион байгуулах арга хэмжээний шалгуур сумд орон зайн стандартыг мөрдүүлсэн байгууллага аж ахуйн нэгжийн хувь гэж заасан боловч тайланд хичнээн аж ахуй нэгжээс хэдэн аж ахуй нэгж орчны шалгуур хангасан талаар тусгах